

Аудитын код: САГ-2018/13/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

Гэрээт аудитор Э.Энхбаатар
Утас: 261740 Цахим хаяг: egji0225@yahoo.com

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудитын гэрчилгээ.....	0
2 Аудитын тайлан	1
2.1 Оршил.....	1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5 Дотоод хяналт.....	3
2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7 Шилэн дансны мэдээлэл	4
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1 Авлагын талаар :	4
2.9.2 Төсвийн зарцуулалтын талаар:	4
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
3 Менежментийн захидал.....	7
3.1 Авлагын талаар	8
3.2 Төсвийн зарцуулалтын талаар.....	9
3.3 Төсвийн зарцуулалтын талаар.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ, БРИГАДЫН ГЕНЕРАЛ
Д.БАТЖАРГАЛ ТАНАА

2018.03.23 № 01/810
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт


Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323\SAG37.Docx

071445

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтэгсэны тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн хэмжээнд урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн, санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл өөрчөгдсөн, урьдчилж олгосон тэтгэмжийг авлагаар бүртгэж тайлагнаагүй зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 19-нөөс 2018 оны 3 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 24-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Отгонхорлоо, гэрээт аудитор Э.Энхбаатар нар хариуцан хэрэгжүүлэв.

Аудитаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 05/1630 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Тус байгууллага нь 2017 онд дараах зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг ханган баталгаажуулахад шинжлэх ухаан, орчин үеийн дэвшилтэт, техник, технологийн арга барилыг ашиглах,
- Байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх,
- Лабораториудад орчин үеийн шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжийг суурилуулах,

Шинжээч, мэргэжилтний мэдлэг боловсролыг байнга дээшлүүлж ур чадварыг ахиулах, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулж хөгжингүй орнуудын холбогдох сургууль, байгууллагуудтай хамтарч ажиллах гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэтгэлийн талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын Засгийн газрын тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон холбогдох бусад хуулиуд, Олон Улсын, Үндэсний болон байгууллагын стандарт, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Шүүхийн шинжилгээний тухай” хууль болон тус байгууллагын үйл ажиллагаанд холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулжээ.

2017 онд тус хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын үндсэн чиг үүргийн дагуу криминалистикийн шинжилгээний чиглэлээр хийх шинжилгээ судалгааны ажилд дэмжлэг үзүүлж 13,202 шинжилгээ,

- Шүүх эмнэлгийн шинжилгээний газар нь шүүх эмнэлгийн чиглэлээр хийх шинжилгээ судалгааны ажилд дэмжлэг үзүүлж 14,002 шинжилгээ,
- Тусгай шинжилгээний газар нь ДНХ-ийн шаардлагатай объектоор төрөлжсөн сан бүрдүүлж ашиглах шинжилгээ 38,090 хийж, дүгнэлт гаргасан,
- Эдийн засгийн шинжилгээний хэлтэс нь эдийн засгийн бусад хэрэг маргаанд шинжилгээ хийж дүгнэлт гарган, эд хөрөнгийн үнэлгээнд дүгнэлт өгөх 231 шинжилгээг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор төдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналт “хангалттай” байна гэж үзлээ.

2017 онд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 1,926.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар системийн хэмжээнд төлөвлөгөө гаргаж батлуулан тодорхой ажлуудыг зохион байгуулсны үр дүнд 4 зөвлөмжийг 92.8 хувьтай тус тус биелүүлсэн ба гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2017 оны мөн оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 1/4357 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2017 онд тус байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх чиглэлээр зөвлөмж, аргачлал гаргаж салбар байгууллагууддаа хүргүүлэн, үр дүнг нь тооцож ажилласан байна. Тухайлбал:

- Төсвийн зарлагыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах,
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргахад анхаарах,
- Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан байгууллагын 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааг дүгнэсэн үнэлгээг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг сайжруулах,
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой,
- Хүрээлэнгийн байгууллагын хэмжээнд үндсэн хөрөнгө, бараа материал, үнэт цаас, мөнгөн хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх, тооцоо бодох, зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь 6 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 10,019.0 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 9,973.6 сая төгрөг буюу 99.6 хувьтай байна. Тайлант онд батлагдсан төсөвт зардлыг 0.4 хувиар хэмнэжээ.



Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 23.7 сая төгрөг буюу 100 хувиар биелсэн байна.

Батлагдсан төсөвт зардлыг зардлын зүйл анги бүрээр хэмнэж ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь шилэн дансанд байршуулах мэдээллээ Шилэн данс нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn>, байгууллагын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбараар бүх мэдээллээ хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

2017 онд өөрийн байгууллагын цахим хуудас болон нэгдсэн цахим хуудасны "Төсөв/гүйцэтгэл", "Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт", "Бусад" зэрэг бүх мэдээллүүдийг байршуулан, улирлын тайлангаа ТЕЗ-ын дотоод аудитын албанд сар бүр илгээж хэвшсэн, ЯАГ-аас 2017 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитад хамрагдаж, хангалттай үнэлгээ авсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын эрсдэлийг 6 чиглэлээр тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлагын талаар :

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь тэтгэвэр тогтоолгоогүй 4 албан хаагчид Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн дагуу 92.9 сая төгрөгийн тэтгэмжийг урьдчилан олгосон боловч авлага үүсгэн бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Авлага дансанд 92.9 сая төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнах зөвлөмж өгөх.


2.9.2 Төсвийн зарцуулалтын талаар:

1.Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2012 оноос хойш өөрийн дансанд бүртгэлгүй, оффисийн зориулалтаар ашиглаж буй байранд их засвар хийж уг засварын зардалд 73.4 сая төгрөгийг дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэж байсныг өмнөх аудитаар залруулах зөвлөмж өгсөн боловч, уг зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандаж шийдвэр гаргуулах.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын зөвлөмжийг цаг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж, идагдан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

2.Тайлант онд бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс данснаас 1.5 сая, багаж хэрэгслийн зардлаас 386.0 сая, тавилга эд хогшлын зардлаас 3.0 сая, урсгал засварын зардлаас 0.1 сая,



бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 48.6 сая нийт 439.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

2.9.3 Орон нутгийн төсвийн зарцуулалтын талаар:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой нийт 316.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа орон нутгийн болон нийслэлийн шүүхийн шинжилгээний газар болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 129.1 сая төгрөгийн залруулага хийгдэж, 1.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах төлбөрийн акт тогтоож, 0.5 сая төгрөгийн албан шаардлага өгч, 186.0 сая төгрөгийн 17 зөвлөмж өгөгдсөн.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

ШШҮХ-гийн төлбөртэй үйлчилгээний үнэ тарифтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэгдсэн асуудлын талаар аудитын явцад тусгайлан шалгасан болно.

Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний 2017 оны А/115, А/17, 142 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжилгээний төлбөр нь бүх насны иргэдэд 3,000-800,000 төгрөг байсан бөгөөд дээрх 3 сайдын 2017 оны А/263, А/406, 321 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан журмаар насанд хүрээгүй иргэнийг үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулахаар өөрчилсөн байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн төсвийн багцын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 791.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 171.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 791.5 сая төгрөгийн алдааг залруулах 20 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 102.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 83.6 сая төгрөгийн алдааг залруулаж 8.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах төлбөрийн акт, 0.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 102.9 сая төгрөгийн алдааг залруулах 26 зөвлөмж өгөгдсөн байна. Өмнөх оны аудитаар тогтоогдсон төлбөрийн акт, 100 хувь, албан шаардлагыг 100 хувь, зөвлөмжийг 100 хувьтай тус тус биелүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 10,422.2 сая төгрөг бөгөөд 2 хувиар буюу 208.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага тогтоогдоогүй болно.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1. АВЛАГЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь тэтгэвэр тогтоолгоогүй 4 албан хаагчид Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн дагуу 92.9 сая төгрөгийн тэтгэмжийг урьдчилан олгосон боловч авлага үүсгэн бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулиудын холбогдох заалтууд зөрчигдөх,

ҮАГ-ын зөвлөмж

Авлагын тооцоог үнэн зөв хийж, баталгаажуулан, авлагын дансанд бодит бус авлагыг бүртгэж, тайлагнахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2012 оноос хойш өөрийн дансанд бүртгэлгүй, оффисийн зориулалтаар ашиглаж буй байранд их засвар хийж уг засварын зардалд 73.4 сая төгрөгийг дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэж байсныг өмнөх аудитаар залруулах зөвлөмж өгсөн боловч, уг зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандаж шийдвэр гаргуулах.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх,

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс данснаас 1.5 сая, багаж хэрэгслийн зардлаас 386.0 сая, тавилга эд хогшлын зардлаас 3.0 сая, урсгал засварын зардлаас 0.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 48.6 сая нийт 439.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, мөн алдааг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		184,145.5	260,649.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а 3б	1,725.5	12,234.5
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		1,725.5	12,234.5
31210	Төгрөг		1,725.5	12,234.5
33500	Бусад авлага		4,748.5	2,072.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	177,062.2	246,342.6
35100	Түүхий эд материал		73,743.1	96,110.4
35400	Хангамжийн материал		103,089.1	150,002.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,027,440.0	4,380,714.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,027,440.0	4,380,714.6
39200	Биет хөрөнгө		4,025,654.1	4,376,729.2
39300	Биет бус хөрөнгө		1,785.9	3,985.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,211,585.4	4,641,364.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,986.9	160.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,986.9	160.5
41300	Өглөг	17а, 17б	3,986.9	160.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,207,598.5	4,641,204.0
51	Засгийн газрын хувь оролцоо		4,207,598.5	4,641,204.0
51200	Хуримтлагдсан үр дүн		(1,296,088.3)	(862,482.8)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,211,585.4	4,641,364.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		8,918,952.9	11,003,692.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		436,067.3	1,027,674.8
120	Нийтлэг татварын бус орлого		436,067.3	1,027,674.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		436,067.3	1,016,804.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1а.1б	8,482,885.6	9,975,266.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		8,242,879.2	9,678,692.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		240,006.4	296,574.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	9,251,909.7	10,422,187.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,251,909.7	10,422,187.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,902,714.8	9,577,687.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6,315,163.0	6,805,729.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		250,995.8	225,380.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		194,986.9	221,983.4
2104	Хангамж, бараа материалын зардал		163,460.1	307,116.7
2105	Нормативт зардал		454,715.9	1,030,806.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		20,050.8	87,516.4
2107	Томилолт, зочны зардал		72,433.9	81,201.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		633,137.3	96,175.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		797,771.2	721,777.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		349,194.9	844,500.5
2132	Бусад урсгал шилжүүлэг		322,826.1	767,204.6
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		26,368.8	77,295.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		(332,956.7)	581,504.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-	151,960.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(332,956.7)	429,544.0

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мянган төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч/
3	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,298,812.7	-758,257.5	4,540,555.3
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0		0.0
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,298,812.7	-758,257.5	4,540,555.3
9	Тайлант үеийн үр дүн	0.0	-332,956.7	-332,956.7
10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,298,812.7	-1,091,214.2	4,207,598.5
11	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,298,812.7	-1,091,214.2	4,207,598.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	4,061.5	4,061.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,298,812.7	-1,087,152.7	4,211,660.0
18	Тайлант үеийн үр дүн	0.0	429,544.0	429,544.0
19	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,298,812.7	-862,482.8	4,641,204.0



4.4. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төсвийн тохируулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		8,825,387.0	10,359,202.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		342,498.4	382,822.8
120	Нийтлэг татварын бус орлого		342,498.4	382,822.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		342,498.4	372,313.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		8,482,888.6	9,976,379.6
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		8,242,879.2	9,678,692.8
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		8,242,879.2	9,678,692.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		240,009.4	297,686.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,676,168.1	9,863,434.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,676,168.1	9,863,434.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,234,735.3	9,006,161.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6,311,346.5	6,788,572.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		255,926.5	227,442.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		194,166.1	222,468.0
2104	Хангамж, бараа материалын зардал		161,923.7	323,039.2
2105	Нормативт зардал		477,922.7	1,050,795.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		27,479.9	114,204.1
2107	Томилолт, зочны зардал		77,138.8	83,412.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		648,143.9	101,703.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		80,687.3	94,524.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		441,432.7	857,272.4
2132	Бусад урсгал шилжүүлэг		415,064.0	779,976.5
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		26,368.8	77,295.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		149,218.9	495,768.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		149,849.0	485,259.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		149,849.0	485,259.3
2200	Дотоод эх үүсвэрээр		149,849.0	485,259.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-149,849.0	-485,259.3
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-630.1	10,509.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,358.5	1,725.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,725.5	12,234.5



4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,019,021.4	9,973,683.9	45,337.5	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,019,021.4	9,973,683.9	45,337.5	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,233,693.8	9,193,707.4	39,986.4	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,793,024.8	6,776,012.4	17,012.4	99.8
210101	Үндсэн цалин	3,940,507.3	3,934,083.1	6,424.2	99.8
210102	Нэмэгдэл	2,185,799.3	2,180,206.6	5,592.7	99.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	666,718.2	661,722.8	4,995.4	99.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,312.6	226,547.0	13,765.6	94.3
210201	Тэтгэврийн даатгал	96,200.0	95,104.5	1,095.5	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	9,620.0	7,907.7	1,712.3	82.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,025.0	9,846.9	2,178.1	81.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,405.0	2,047.8	357.2	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	120,062.6	111,640.0	8,422.6	93.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	226,369.4	222,268.0	4,101.4	98.2
210301	Гэрэл, цахилгаан	64,794.7	62,816.2	1,978.5	97.0
210302	Түлш, халаалт	118,194.7	117,514.4	680.3	99.4
210303	Цэвэр, бохир ус	29,399.8	27,957.3	1,442.5	95.1
210304	Байрны түрээс	13,980.2	13,980.2	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	320,394.3	318,441.0	1,953.3	99.4
210401	Бичиг хэрэг	59,352.7	59,341.3	11.4	100.0
210402	Тээвэр, шатахуун	142,872.6	142,737.9	134.7	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,400.0	37,704.9	1,695.1	95.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,856.4	16,856.4	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	61,912.6	61,800.5	112.1	99.8
2105	Нормативт зардал	1,017,214.3	1,017,076.2	138.1	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	404,862.3	405,134.4	-272.1	100.1
210502	Хоол, хүнс	54,239.0	53,828.7	410.3	99.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	558,113.0	558,113.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	381,257.4	380,945.9	311.5	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	305,603.5	305,594.1	9.4	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	43,245.5	42,979.0	266.5	99.4

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210604	Урсгал засвар	32,408.4	32,372.8	35.6	99.9
2107	Томилолт, зочны зардал	83,140.5	81,493.2	1,647.3	98.0
210701	Гадаад албан томилолт	0.0	0.0	0.0	0.0
210702	Дотоод албан томилолт	83,140.5	81,493.2	1,647.3	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	144,385.6	143,328.9	1,056.7	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,956.0	94,565.2	390.8	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,269.8	1,139.0	130.8	89.7
210803	Даатгалын үйлчилгээ	3,168.0	3,168.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,485.0	1,485.0	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	341.5	341.0	0.5	99.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,850.0	31,850.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	534.6	0.0	534.6	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,780.7	10,780.7	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,594.9	27,594.9	0.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,367.5	12,367.5	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,227.4	15,227.4	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	785,327.6	779,976.5	5,351.1	99.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	785,327.6	779,976.5	5,351.1	99.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	606,127.6	605,289.6	838.0	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	179,200.0	174,686.9	4,513.1	97.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,019,021.4	9,973,750.0	45,271.4	99.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,678,692.8	9,633,421.4	45,271.4	99.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	9,678,692.8	9,633,421.4	45,271.4	99.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	340,328.6	340,328.6	0.0	100.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	316,548.6	316,548.6	0.0	100.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,780.0	23,780.0	0.0	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	9.0	-9.0	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23.0	23.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	23.0	23.0	0.0	100.0

610002	Төсвөөс гадуур байгууллага	0.0	0.0	0.0	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	514.0	514.0	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	34.0	34.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	448.0	448.0	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32.0	32.0	0.0	100.0
620004	Гэрээт ажилтан	0.0	0.0	0.0	0.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	514.0	514.0	0.0	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	493.0	493.0	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.0	12.0	0.0	100.0



Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2018/13/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрэээн			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	8	9
1	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь тэтгэвэр тогтоолгоогүй 4 албан хаагчид Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн хуулийн дагуу 92.9 сая төгрөгийн тэтгэмжийг урьдчилан олгосон боловч авлага үүсгэн бүртгэж, тайлагнаагүй байна.	92.9	Менежментийн захидлаар зөвлөмж өгөх	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Алтанхишиг Ө.Сэр-Од
2	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аппаратын дансанд бүртгэлтэй 30.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Баян-Өлгий аймгийн шүүхийн шинжилгээний алба давхар бүртгэж тайлагнасан.	30.2	Аудитын явцад залруулсан	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Алтанхишиг Ө.Сэр-Од
3	Хэнтий аймгийн шүүхийн шинжилгээний алба үндсэн хөрөнгийн элэгдлийг 7.0 төгрөгөөр дутуу тооцсон байна.	-	Аудитын явцад залруулсан	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Алтанхишиг Ө.Сэр-Од
4	Тайлант оны цалингийн сангаас ахмадын санд хөрөнгө төвлөрүүлсэн, мөн уг сангийн дүнгээр 2016 оны жилийн эцсийн аудит хийсэн тайланд өөрчлөлт оруулсан байна. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аппарат 9.5 сая, Дундговь аймгийн шүүхийн шинжилгээний алба 2.3 сая төгрөгөөр тус тус эхний үлдэгдэл өөрчлөгдсөн байна.	11.9	Аудитын явцад залруулсан	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Алтанхишиг Ө.Сэр-Од
Нийт дүн		135.0			

